



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр

Улаанбаатар сарын 10-ны өдөр

126

Дугаар

хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.3, 13.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журмыг 1 дүгээр, 2013 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дараахь арга хэмжээ авахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгасугай:

2.1. Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 70200 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх ажлыг 2013 оны 3 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах;

2.2. Компанийн нөөц бүрдүүлж байгаа аж ахуйн нэгжид санхүүгийн болон холбогдох бусад дэмжлэг үзүүлж, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын багтаамжийг нөөцтэй нь уялдуулан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3. Газрын тосны бүтээгдэхүүний тухайн жилд бүрдүүлэх компанийн нөөцийн талаарх саналаа боловсруулж өмнөх оны 8 дугаар сард багтаан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байх.

3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 70200 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэх арга хэмжээ авч, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөцийн бүрдүүлэлт, чанарт байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын тосны газарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Уул уурхайн сайд

Н.АЛТАНХУЯГ
Д.ГАНХУЯГ